

Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Газар, хэлтсийн нэр	Үндсэн чиг үүрэг
4. Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	• Төрөөс баримтлах урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын чиглэлээр тусгуулах санал, төсөл боловсруулах, батлагдсан зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах; • хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбар /цаашид “салбар” гэх/-ын бодлогыг төлөвлөх, боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах; • салбарын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдамж, мэргэжил, арга зүйн зохицуулалтаар хангах, зохион байгуулах, бусад салбартай ажлын уялдааг ханган хамтран ажиллах; • салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах; • салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдамж, чиглэл, зохицуулалт, зөвлөгөө дэмжлэгээр хангах, үнэлэлт дүгнэлт өгөх; • салбарын суурь судалгаа, мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол баяжилт хийх, салбарын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх; • салбарт орчин үеийн шинжлэх ухааны ололт, дэвшилтэд техник, технологи, инновацийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх; • салбарын чиглэлээр боловсон хүчин, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхтэй холбогдсон бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; • салбарын ногоон, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, загварыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; • хот байгуулалт, газрын зохион байгуулалт, кадастр, геодези, зураг зүйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; • хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, харилцан уялдааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих; • хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; • хот байгуулалтын баримт бичигт улсын экспертиз/магадлал/-ийн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах; • аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд дүгнэлт өгөх, түүний хэрэгжилт болон газар зохион байгуулалт, газрыг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих; • улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах ажлыг зохион байгуулах;

	• газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох болон нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, холбогдох шийдвэрийг гаргуулах ажлыг зохион байгуулах; • салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын тэргүүн туршлага, арга зүй, аргачлалыг судлах, өөрийн оронд нэвтрүүлж, нутагшуулах ажлыг холбогдох байгууллагуудтай зохион байгуулах; • салбарын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд төр, нутгийн захиргаа, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, нэгдсэн удирдамж, чиглэл, салбар дундын зохицуулалтаар хангах, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл харилцан солилцох; салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн талаар УИХ, ЗГ, яамд, бусад холбогдох байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хамтран ажиллах.
--	--